



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 26 өдөр

Дугаар Б/48

Бор-өндөр сум

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйл 42.2, 42.2.3 123 дугаар зүйлийн 123.1, 123.2, 123.2.2, 123.3, Нэгдсэн эмнэлгийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 12 дугаар зүйл 12.6, 12.6.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Мэс заслын эмч Эрдэнэбилэгийн Гантулга нь ажлын байран дээр архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ ирсэн, Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндсэн үүргээ биелүүлээгүй, Нэгдсэн эмнэлгийн дотоод журамд заасан заалтуудыг зөрчсөн тул сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Сахилгын шийтгэлийг нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах, 1 жилийн үр дүнгийн урамшууллыг хасаж тооцсугай.

3. Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу өдөр тутмын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг баримтлан ажиллаж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг Э.Гантулгад үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн (Б.Халиун)-д даалгасугай.

ДАРГА

А.БАТБААТАР

